

## Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт Компанийн төлөөллийг томилох, ажиллах журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг /цаашид “Санаачилга” гэх/ хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газар, компани, иргэний нийгмийн хамтарсан 3 талт үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/, ажлын хэсэгт /цаашид “Ажлын хэсэг” гэх/ орох компаниуд, мэргэжлийн холбоод, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжүүдийн /цаашид “Компани” гэх/ төлөөллийг томилох, ажиллуулах, эгүүлэн татах асуудлыг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолын 1 болон 3 дугаар зүйлд заасны дагуу компани нь Үндэсний зөвлөлд 10, Ажлын хэсэгт 11 гишүүнээ томилон ажиллуулна.
- 1.3. Мөн тогтоолын 6 дугаар зүйлд заасны дагуу Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт компанийн төлөөллийг сонгох, томилох ажлыг Монголын уул уурхайн үндэсний ассоциаци /цаашид “Ассоциаци” гэх/ хариуцан зохион байгуулна.

### Хоёр. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүнийг сонгох, томилох

- 2.1. Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн компанийн төлөөлөлд, ашигт малтмал, түгээмэл тархацтай болон цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны чиглэлээр хайгуул, ашиглалт эрхэлдэг том, дунд, жижиг компаниуд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж /цаашид аж ахуйн нэгж гэх/, геологи, уул уурхайн чиглэлээр ажилладаг мэргэжлийн холбоодын /цаашид холбоод гэх/ төлөөллийг бүрэн хамруулна.
- 2.2. Ассоциациас нэр дэвшүүлэх зарыг хэвлэлээр зарлаж, холбогдох байгууллагуудад бичгээр хүргүүлж болно.
- 2.3. Тавигдах шаардлагыг хүлээн зөвшөөрсөн Компани болон мэргэжлийн холбоодоос өөрийн төлөөллийн гишүүнд нэр дэвшүүлж, саналаа Ассоциацид Зар гарснаас хойш хуанлийн 14 хоногт багтаан бичгээр ирүүлнэ.
- 2.4. Ассоциаци нэр дэвшигчдийн жагсаалтыг гарган, үнэлгээ хийж, тэргүүлэх оноог жагсаалт гарган, хуанлийн 14 хоногт хэвлэн нийтлүүлнэ.
- 2.5. Олонхийн санал авсан нэр дэвшигчдийг томилогдсонд тооцож нэрсийг Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолд заасны дагуу ассоциацийн ерөнхийлөгч Үндэсний зөвлөлийн даргад хэвлэлд нийтлүүлсэн мэдээний хамт бичгээр ирүүлнэ.

### Гурав. Тавигдах шаардлага

- 3.1 Гишүүнд нэр дэвшүүлж аж ахуйн нэгж нь ОУИТБС-н стандартын дагуу хамгийн багадаа сүүлийн дараалсан 3 жил тайлангаа гаргасан байх.
- 3.2 Холбоод нь салбартаа 3-аас доошгүй жил тогтвортой ажилласан байх.
- 3.3 Аж ахуйн нэгж, холбоод ОУИТБС-ын стандарт, зарчим, алсын харааг хүлээн зөвшөөрч, мөрдөхөө илэрхийлсэн байх.
- 3.4 Аж ахуйн нэгж, холбоод нь ОУИТБС-ын Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд орох гишүүнээ томилон батлаж, ажил үүргийн хуваарьт холбогдох нэмэлтийг оруулсан байх.

- 3.5 Аж ахуйн нэгж, холбоодын гишүүнээр томилогдох хувь хүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.5.1 Монгол улсын иргэн байна.
  - 3.5.2 Тухайн байгууллагад 2-оос доошгүй жил ажил ажилласан байна.
  - 3.5.3 Үндэсний зөвлөл, Ажлын хэсэгт гишүүнээр орохоо зөвшөөрсөн байна.
  - 3.5.4 ОУИТБС-ын зарчим, дүрмийг чанд биелүүлэхээ илэрхийлсэн байна..
  - 3.5.5 Товч намтараа ирүүлсэн байна.

Дөрөв. Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүний эрх үүрэг

- 4.1 Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн гишүүнийг 2 жилийн хугацаатай томилох бөгөөд улиран ажиллуулж болно. Ямар хязгаар тавихгүй болно.
- 4.2 Гишүүн нь Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаанд заавал оролцох, хэрэв биечлэн оролцох боломжгүй бол төлөөллөө оролцуулах үүрэгтэй.
- 4.3 Гишүүн нь төлөөлж буй салбарынхаа аж ахуйн нэгжүүдтэй байнгын харилцаатай байж, Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар тэдний саналыг авч, санал хүсэлтийг нь илэрхийлэх бөгөөд гарсан шийдвэрийг мэдээлэх үүрэгтэй.
- 4.4 ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн ажиллах журамд заасан бусад эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.5 Жил бүр аж ахуйн нэгжийн төлөөллийн ирц, үйл ажиллагаанд оролцсон оролцоог харгалзан үнэлгээ өгнө.
- 4.6 Үнэлгээний дүн нь тухайн аж ахуйн нэгжийн цаашид ажлын хэсэг, үндэсний зөвлөлд байх эсэхэд шууд нөлөөлж болно.
- 4.7 Сонгогдсон хугацаанд хангалттай үнэлгээтэй ажилласан аж ахуйн нэгжийг улиран ажиллах боломжтой.
- 4.8 Аж ахуйн нэгж нь өөрийн хүсэлтээр, эсвэл давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан ажлын хэсэг, үндэсний зөвлөлөөс гарах бол албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

Тав. Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүнийг эгүүлэн татах

- 5.1 Гишүүнийг эгүүлэн татах, чөлөөлөх асуудлаар Үндэсний зөвлөл, Ажлын хэсэг л санал гаргах эрхтэй бөгөөд санал хураалтаар шийдвэрлэнэ.
- 5.2 Гишүүнийг дараах үндэслэлээр эгүүлэн татах асуудлыг хэлэлцэнэ.
  - 5.2.1 Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон.
  - 5.2.2 Өөрөө хүсэлт гаргасан болон өөр албан тушаалд томилогдсон.
  - 5.2.3 Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн хуралдааныг дараалан 3 удаа хүндэтгэх шалтгаангүйгээр тасалсан.
  - 5.2.4 Төлөөлж буй салбарынх нь аж ахуйн нэгжүүдээс эгүүлэн татах тухай санал гарсан.